

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт туссан арга хэмжээ, зорилт							
Зорилт 1 “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 3.5, ЗГҮАХ “2024-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.4, МУХТЖҮЧ-ийн 1.2.2							
1.1.1	МУЕ-ийн 53 дугаар зарлиг Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг зохион байгуулах, сорилын программд үр дүнг шивж оруулах	-	Хамрагдсан иргэдийн хувь	10,8 хувь	11,0 хувь	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлигийн дагуу Бие бялдрын түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг 04 дүгээр сарын 01-ээс 5 дугаар сарын 20-ний өдрүүдэд зохион байгуулж 6213 иргэн хамруулж, үр дүнг www.cpanel.sport.gov.mn сорилын программд шивж оруулсан. Эхний хагас жилд нийт хүн амын 5,8 хувийг сорилд хамруулсан.	100
			А, В, С үнэлгээтэй иргэдийн хувь	73,4 хувь	74 хувь	Сорилд хамрагдсан 6213 хүний 79,4 хувь нь (А үнэлгээтэй 1811, В үнэлгээтэй 1635, С үнэлгээтэй 1491 нийт 4937 иргэн) АВС үнэлгээтэй байна.	100
1.1.2	МУЕ-ийн 53 дугаар зарлиг, АЗДҮАХ 2.4.1.4 “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-д сорилын үйл ажиллагааг зохион байгуулах	-	Сорилын төвөөр үйлчлүүлсэн хүний тоо	833	870	“Сорилын төв”-д эхний хагас жилд эрэгтэй 136, эмэгтэй 193 нийт 329 иргэнийг бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулсан. Үүнээс 193 иргэн таргалалттай, 109 хүн хэвийн жинтэй, 121 хүн чийрэгжүүлэх төвөөр үйлчлүүлж, дасгалд хамрагдан, зөвлөгөө авсан. Эхний хагас жил 435 хүн үйлчлүүлэхээс 329 иргэн үйлчлүүлсэн байна.	76,0
1.1.3	МУ-ын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг Бүх нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	-	Хамрагдсан иргэдийн тоо	102,892	103,000	Бүх нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээг төрийн бус байгууллага, спорт холбоодтой хамтран зохион байгуулж эхний хагас жилд давхардсан тоогоор эрэгтэй 26948, эмэгтэй 22375 нийт 49923 иргэнийг 221 арга хэмжээнд хамруулсан.	98,5
			Арга хэмжээний тоо	237	240		

						Эхний хагас жилд 51500 иргэн хамруулахаас 49923 иргэн хамруулсан.	
1.1.4	БТСтХ-ийн 30 дугаар зүйл, ХБХЭтХ-ийн 33, 42 дугаар зүйл Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран тэмцээн, биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах	-	Хамрагдсан ХБИ-ийн тоо	-	50	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг мэргэжлийн холбоотой хамтран Баянгол суманд 04 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд "Бид хамтдаа" уриан дор биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж 11 сум, тосгоны эрэгтэй 80, эмэгтэй 57 нийт 137 иргэнийн дунд 3 спортын төрлөөр зохион байгуулсан.	100
			Пара спортын төрлийн тоо	2	3		
1.1.5	АЗДҮАХ 2.4.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд аян зохион байгуулж, "Би сэлж сурлаа" анхан шатны тэмцээн зохион байгуулах	-	Хамрагдсан сурагчдын тоо	132	145	Ерөнхий боловсролын бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд Усанд сэлэлтийн 1 сарын аяныг 04 дүгээр сарын 20-оос 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж 7 сургууль, 2 цэцэрлэгийн 5-17 насны, эрэгтэй 925, эмэгтэй 880 нийт давхардсан тоогоор 1805 сурагч хамрагдсан. Аянд хамрагдсан сурагчдын дунд "Би сэлж сурлаа" анхан шатны тэмцээнийг 05 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулж эрэгтэй 44, эмэгтэй 42 нийт 86 сурагч оролцсон. Нийт 2 арга хэмжээнд давхардсан тоогоор 1891 сурагч хамрагдсан.	100
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2		
1.1.6	АЗДҮАХ 2.4.1.5 "Сэлэнгийн Мөнгөн Өвөл-2026" арга хэмжээг иргэдийн дунд зохион байгуулах	-	Хамрагдсан иргэдийн тоо	132	150	Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1, Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өвлийн спортыг сурталчлах, зорилготойгоор "Түнхэл Өвлийн наадам 2026" арга хэмжээг 02 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд спортын 8-н төрлөөр зохион байгуулж 420 иргэн хамрагдсан. "Хараагийн мөнгөн өвөл-2026" наадмыг 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Мандал суманд зохион байгуулж 35 байгууллагын 1200 гаруй иргэн оролцсон. 1620 иргэн, 8 спортын төрлийн арга хэмжээнд хамрагдсан.	100
			Спортын төрлийн тоо	2	3		
1.1.7	АНТХ-ийн 11.1.2 Ахмадын нас биеийн онцлогт тохирсон тэмцээн, биеийн тамирын арга	-	Хамрагдсан иргэдийн тоо	130	150	Ахмад тамирчдын нас, биеийн онцлогт тохирсон нийтийн биеийн тамир, спортын тэмцээнийг спорт холбоод болон сумдын Спорт цогцолборуудтай хамтран волейбол, мөсөн сур, нумт	100

	хэмжээг спорт холбоодтой хамтран зохион байгуулах		Арга хэмжээний тоо	2	3	харвааны төрлөөр 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Сэлэнгэ аймгийн сум, тосгодын давхардсан тоогоор нийт 240 ахмад тамирчин оролцсон байна. Шалгуур үзүүлэлтийн дагуу 240 ахмадыг 3 арга хэмжээд хамруулсан.	
1.1.8	БТСгХ-ийн 13.1.4, АЗДУАХ 2.4.1.3 Улс, аймаг, бүсийн болон нэрэмжит тэмцээнийг спорт холбоодтой хамтран зохион байгуулах	-	Тэмцээний тоо, оролцогчдын тоо	20 тэмцээн 1351 иргэн	21 тэмцээн 1450 иргэн	Спорт холбоо, спорт цогцолбор, төр, төрийн бус байгууллагуудтай хамтран аймаг, бүс, нэрэмжит тэмцээнийг спортын 7 төрлийн тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 3,667 тамирчин хамрагдсан. Үүнд: "Сэлэнгэ Лиг-2026" спортын наадамд 17 сум, 6 тосгоны 1320 тамирчин, "Түнхэл Өвлийн наадам-2026"-д 420 гаруй тамирчин, "Хараагийн мөнгөн өвөл-2026" наадамд 1200 иргэн, "Сүхбаатар Кап" олон хотын чөлөөт бөхийн тэмцээнд улс, аймаг, дүүрэг, клуб, ОХУ-ын Буриад, Тува улсын нийт 27 байгууллагын 450 тамирчин, Монгол Улсын Аварга Г.Эрхэмбаярын нэрэмжит улс, аймгийн алдар цолтой хүчит 128 бөхийн барилдаан, "Би сэлж сурлаа" тэмцээнд 86 өсвөрийн тамирчин, Төвийн бүсийн усанд сэлэлтийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд 155 өсвөрийн тамирчин оролцсон. Сэлэнгэ аймгийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 14 төрлөөр зохион байгуулж 3759 гаруй тамирчин хамрагдсан. Үүнд: Үндэсний бөх, модон барилдаан, шатар, волейбол U13, U14, U17, чөлөөт бөх U15, U17, ширээний теннис, 100. буудалт даам, жүдо бөх, хөнгөн атлетик, сагсан бөмбөг, U18, U11, хөлбөмбөг, буудлага, футзал. Нийт 21 төрлийн тэмцээнд 7126 тамирчин хамрагдсан.	100
1.1.9	Улс, аймаг, бүс, нэрэмжит тэмцээнд Өсвөр үе, насанд хүрэгчдийг оролцуулах	-	Хамрагдсан иргэдийн тоо, тэмцээний тоо	1584 иргэн, 15 тэмцээн	1650 иргэн, 20 тэмцээн	Өсвөр, идэрчүүд, насанд хүрэгчдийн ангиллаар 35 удаагийн улс, бүс, аймгийн чанартай тэмцээнд давхардсан тоогоор 1,780 гаруй өсвөр, насанд хүрэгч тамирчдыг оролцуулсан. (жүдо, чөлөөт	100

						бөх, волейбол, сагсан бөмбөг, бадминтон, шатар, ширээний теннис, буудлага, модон барилдаан, хөнгөн атлетик, хөл бөмбөг)	
1.1.1 0	Үндэсний спортын тэмцээнийг спорт холбоотой хамтран зохион байгуулах	-	Тэмцээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	2 тэмцээн, 120 иргэн	3 тэмцээн, 130 иргэн	Монгол үндэсний уламжлалт өв соёл, спортын төрлүүдийг орон нутагт сэргээн хөгжүүлэх, үндэсний тоглоом наадмыг иргэдэд сурталчлах, өвлүүлэн үлдээх чиглэлээр үндэсний спортын холбоодтой хамтран 5 төрлийн тэмцээн зохион байгуулж 774 иргэн хамрагдсан. Үүнд: Үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 90, Нэрэмжит барилдаанд өсвөр үе 114 бөх, Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат Улсын аварга Гунаажавын Эрхэмбаярын нэрэмжит барилдаанд 128 бөх, Шагайн харваа тэмцээнд байгуулж 18 багийн 144 харваач, "Ерөө Кап" мөсөн сурын харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд, 8 багийн 64 харваач хамрагдсан.	100
1.1.1 1	БТСтХ-ийн 13.1.4 Өвлийн багийн спортын тамирчдын ур чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлэх	-	Дэмжлэг үзүүлсэн тамирчдын тоо	21 тамирчин	30 тамирчин	Монголын Үндэсний спортын өвлийн наадамд Сэлэнгэ аймгаа төлөөлөн оролцох мөсний сурын 12, мөсний шагайн 6, нийт 18 тамирчинд Сэлэнгэ аймгийн Засаг дарга 6,054,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Ерөө Кап" мөсний сурын харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Ерөө сумын Засаг даргын дэмжлэгээр зохион байгуулж 8 багийн 64 харваачийг хамруулсан.	100
1.1.1 2	БТСтХ-ийн 13.1.4, АЗДУАХ 2.4.1.3 Өсвөрийн шигшээ спортын төрлийг нэмэгдүүлэх	-	Спортын төрөл	8 спорт	10 спорт	Сэлэнгэ аймгийн өсвөрийн тамирчдын залгамж халааг бэлтгэх, спортын төрлийг олшруулах, өндөр амжилт гаргах ирээдүйтэй авьяаслаг хүүхдүүдийг дэмжих чиглэлээр өсвөрийн шигшээ багийн спортыг 2 төрлөөр нэмэгдүүлсэн. Сэлэнгэ аймагт өсвөрийн шигшээ багийн спортын 10 төрөл (усанд сэлэлт, бадминтон, жудо, самбо, модон барилдаан, чөлөөт бөх, хөнгөн атлетик, бокс, сагсан бөмбөг, волейбол)-д нийт 233 тамирчин, 10 дасгалжуулагч бэлтгэл сургалтаа хэвийн явуулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчдын тэмцээнд оролцох зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон үйл	100

						ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас нийт 85,585,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Мөн тив, дэлхийн улсын чанартай тэмцээнд амжилт гаргасан тамирчин сурагч, багийн төрлөөр амжилт гаргасан тамирчдад хүндэтгэл үзүүлэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс 61,100,000 төгрөгийн урамшуулал олгосон.	
1.1.1 3	Спортын хэрэглэл материалын хуртээмжийг сайжруулах	-	Спортын хэрэглэл материалын тоо	-	6	Үндсэн үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлж, спортын хэрэглэл, материал авахаар төсвийн саналаа Биеийн тамир, спортын Улсын хороонд хүргүүлсэн. Тус арга хэмжээ хүлээгдэж байна.	-
1.1.1 4	БТСтХ-ийн 13.1.10 Шинээр хөгжиж буй спортын төрлийг хөгжүүлж, иргэдэд сурталчилах	-	Спортын төрлийн тоо	-	3	Сэлэнгэ аймагт нутагшуулах, иргэд, хүүхэд залуучуудад таниулан сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулсан. Бадминтон, Модон барилдаан, Тийболын спортыг иргэдэд таниулах, сурталчлах өдөрлөг, нээлттэй бэлтгэлүүдийг зохион байгуулж, спортын дүрэм, ач холбогдлыг сурталчилсан контентыг цахим хуудсаар түгээж, өсвөрийн шигшээ багийн шинэ төрөл болгон сурталчилж байна. Шинээр хөгжиж буй 3 спортын төрлийг онцлон иргэдэд сурталчилж, анхан шатны мэдлэг олгох сургалт, тэмцээн зохион байгуулсан.	100
1.1.1 5	Хамтарсан бэлтгэл, сургалтыг Аймгийн хэмжээнд зохион байгуулах	-	Бэлтгэл сургалтын тоо, хамрагдсан тамирчны тоо	2 бэлтгэл, 130 тамирчин	3 бэлтгэл, 140 тамирчин	Аймгийн хэмжээнд чөлөөт бөх, жүдо бөх, хөнгөн атлетик, усанд сэлэлтийн өсвөрийн тамирчдын 4 удаагийн хамтарсан бэлтгэлийг зохион байгуулж 245 тамирчин хамруулсан.	100
Зорилт 1.2 "Спортлог Сэлэнгэ"-чүүд хөтөлбөрийн хүрээнд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах							
1.2.1	БТСтХ-ийн 13.1.4, АЗДУАХ 2.4.1.1 "Сэлэнгэ Марафон" гүйлтийн арга хэмжээг зохион байгуулах	25,000,000₮	Хамрагдсан иргэдийн тоо	1000	1050	Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын нэрэмжит "Сэлэнгэ Марафон" 5 дах удаагийн бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газар, Монголын хэт холын Марафон Гүйлтийн Холбоотой хамтран 06 дугаар сарын 06-ны өдөр Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд амжилттай зохион байгуулсан. 6300 иргэн, тамирчин, 17 сум, 6 тосгон, 5 аймаг, гадаадын 2 иргэн.	100
			Оролцсон Сумдын тоо	9	10		
			Оролцсон аймгийн тоо	3	4		

1.2.2	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 Монголын уламжлалт тоглоом, наадгайн арга хэмжээг зохион байгуулах	1,712,000₮	Хамрагдсан иргэдийн тоо	23	30	Хугацаа болоогүй	-
1.2.3	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын тэмцээн, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	25,000,000₮	Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо	600	650	Хугацаа болоогүй	-
			Албан байгууллагын тоо	30	32		
1.2.4	"Сэлэнгийн Оюутан Залуус-2026" Спортын II наадмыг зохион байгуулах	15,000,000₮	Хамрагдсан оюутны тоо	292	320	Хугацаа болоогүй	-
1.2.5	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 "Сэлэнгэ Лиг-2026" спортын наадмыг зохион байгуулах	75,000,000₮	Хамрагдсан иргэдийн тоо	1200	1250	"Сэлэнгэ Лиг-2026" спортын наадмыг Аймгийн Засаг даргын А/05 дугаар захирамжийн дагуу 01 дүгээр сарын 16-18-нд Улаанбаатар хотноо Буянт-Ухаа спортын ордонд спортын 5 төрөлд (сагсан бөмбөг, волейбол, шатар, ширээний теннис, шагай) зохион байгуулж 17 сум, 6 тосгоны 1320 иргэн хамрагдсан.	100
			Оролцсон сум, тосгоны тоо	15	17		
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
2.1	НМИТБтХ-ийн 8 дугаар зүйл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, газар болон цогцолборын ил тод байдлын хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	80%	90%	Байгууллагын болон харьяа Спорт цогцолбор, Усан спортын сургалтын төвийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэдийг үнэн зөв, бодит мэдээллээр тогтмол хангах ажлыг цаг хугацаанд нь зохион байгуулж хагас жилийн байдлаар хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Үйл ажиллагаа болон Хүний нөөцийн ил тод байдал: Байгууллагын бүтэц зохион байгуулалтын схем, үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, сул орон тооны зар болон төрийн албаны тангараг өргөх ёслолын арга хэмжээ зэрэг хүний нөөцтэй холбоотой шийдвэрүүдийг байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар, www.shilen.gov.mn сайтад нээлттэй байршуулсан. Төсөв, санхүүгийн ил тод байдал: Батлагдсан 2026 оны нийт төсөв / 2,214,110,100 төгрөг/ болон улсын	94

						<p>төсвийн урсгал зардал /1,372,421,800 төгрөг/, орон нутгийн төсвийн санхүүжилт /909,751,600 төгрөг/-ийн эхний 6 сарын гүйцэтгэл, зардлын зарцуулалтыг Шилэн дансны тухай хууль болон НМИТБТХ-ийн дагуу сар бүр цахим системд хугацаанд нь ил тод мэдээлсэн.</p> <p>Орон нутагт зохион байгуулагдсан тэмцээн уралдааны удирдамж, дүн, хамрагдсан иргэд, тамирчдын тоон мэдээллийг олон нийтэд тогтмол нээлттэй мэдээлэв.</p> <p>Байгууллагын болон харьяа цогцолборын үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг хуульд заасан хугацаанд, стандартын дагуу цахим орчинд нээлттэй байршуулан хэвшсэнээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт 94% хувь, хагас жилийн байдлаар шалгуур үзүүлэлт бүрэн хангасан.</p>	
2.2	ЗГХЭГД-ын 100 дугаар тушаал Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хагас, бүтэн жилээр тайлагнах	-	Хэрэгжилтийн хувь	95%	96%	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 100 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэх аргачлал"-ыг чанд мөрдөн ажилласан. Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд баталж, төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хагас жилийн байдлаар нэг бүрчлэн дүгнэв. ЗГХЭГ-ын 100 дугаар тушаалын аргачлалын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг чанаржуулж, цахим системд хугацаанд нь тайлагнаснаар тус заалтын хэрэгжилтийн хувь хүрч, шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан.</p>	100
2.3	ҮСХД-ын А/646 тоот тушаал Байгууллагын жилийн статистик мэдээг нэгтгэж хүргүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны А/646 дугаар тушаалаар баталсан маягт, зааврын дагуу байгууллагын жилийн статистик мэдээг нэгтгэн тайлагнах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус заалт нь жилийн эцсээр нэгдсэн дүнгээр гарч, албан ёсоор хүргэгддэг ажил тул хагас жилийн тайлант хугацаанд хэрэгжих хугацаа нь болоогүй байна.</p>	100

						Гэсэн хэдий ч хагас жилийн хугацаанд зохион байгуулагдсан нийтийн биеийн тамирын арга хэмжээнүүд, "Сэлэнгэ лиг-2026" спортын наадам, "Хөдөлгөөнөөр эрүүлжье" аян болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийн баг тамирчид, хамрагдсан иргэдийн анхан шатны тоо баримт, статистик мэдээллийг тухай бүрд нь бүртгэл хийн архивлав. Ингэснээр жилийн эцсийн статистик тайланг алдаа мадаггүй, бодит үр дүнд суурилан үнэн зөв гаргах хуулийн шаардлага, суурь нөхцөлийг бүрэн бүрдүүлээд байна.	
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
3.1	ЗГ-ын 43 дугаар тогтоол Байгууллагын 2026 оны Хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайлангийн тоо	4	5	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 4,7-д заасны дагуу 2025 оны хагас жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг удирдлага болгон хийсэн.	100
			Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байдал	4	5	Биеийн тамир, спортын улсын хороо, Аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.	100
3.2	ЗГ-ын 311 дугаар тогтоол Байгууллагын Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах	-	Дотоод аудит хийсэн тайлан, зөвлөмж	3	6	Байгууллагын дотоод хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 6 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.1 дэх заалтын дагуу Биеийн тамир спортын газрын 2025 оны үйл ажиллагааны нэмэлт орлогын	100

						бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүнд дотоод хяналт шалгалтыг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 02 дугаар сарын 27-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.	
			Төрийн аудитаас ирүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн хүрээнд зохион байгуулсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	1	1	2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн санхүүгийн аудитаар алдаа, зөрчил дутагдал илрээгүй болно.	100
3.3	БТСтХ-ийн 14.1.6 Биеийн тамир, спортын салбарын улсын IV зөвлөгөөнд оролцох	-	Албан хаагчдын тоо	35	40	Хугацаа болоогүй	-
3.4	ТАЗ-ийн 2025 оны 521 дугаар тогтоол "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу харьяа Спорт цогцолборуудын эрхлэгч, арга зүйч нарын болон төрийн албан хаагчдын хувийн хэргийг хөтөлж, баяжилт хийх	-	Хувийн хэрэг баяжилт хийсэн эсэх, Хувийн хэрэг баяжилт хийсэн албан хаагчдын тоо	64	64	Тус газрын үндсэн албан хаагчид болон харьяа сум, тосгоны Спорт цогцолборуудын эрхлэгч, арга зүйч нарын хувийн хэрэгт журамд заасны дагуу тухай бүр нь баяжилт, хөдөлгөөнийг үнэн зөв хийж, баримтжуулалтыг чанаржуулсан. Төрийн албан хаагчдын анкетаас гадна боловсролын диплом, мэргэшүүлэх сургалтын гэрчилгээ, шагнал урамшуулал, үр дүнгийн гэрээний биелэлт болон бусад шаардлагатай тушаал шийдвэрүүдийг цаг тухайд нь хувийн хэрэгт нь хавсаргаж, баяжуулалтыг нэг бүрчлэн гүйцэтгэв. Хагас жилийн байдлаар тус газрын харьяанд хамаарах нийт 64 албан хаагчийн хувийн хэргийн баяжилт хийсэн.	100
3.5	Байгууллагын албан хаагчдын 2026 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	85%	90%	Байгууллагын албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор баталсан "Албан хаагчдын 2026 оны сургалтын төлөвлөгөө"-ний хагас жилийн биелэлтийг бүрэн хангаж ажиллалаа. Энэ хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэрэгцээнд суурилсан нийт 27 удаагийн сургалтыг шат дараатай зохион байгуулж, давхардсан тоогоор 649 албан хаагчийг хамруулав.	100

						<p>Хагас жилд зохион байгуулагдсан болон хамрагдсан сургалтууд: -Ажил олгогчийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт; -Удирдлагын академиас зохион байгуулсан "Дижитал ёс зүй" сэдэвт 2 өдрийн сертификаттай сургалт; -Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан сургалт; -Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргах, хүргүүлэх журам"-ын цахим сургалт; -Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах" сургалт; -Байгууллагаас дотооддоо зохион байгуулж буй "Монгол бичиг"-ийн сургалт; -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "7:4:10" сургалт Мөн албан хаагчдын ажиллаж удирдах чадавхыг дэмжих хүрээнд "Мон-Алтус" дээд сургууль, Дархан дээд сургуульд тус бүр 1, Хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийн академид 1 албан хаагчийг тус тус суралцуулах нөхцөлийг бүрдүүлэн, дэмжлэг үзүүлсэн</p>	
3.6	Байгууллагын албан хаагчдын 2026 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	-	Хэрэгжилтийн хувь	80%	85%	<p>Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Хөдөлмөрийн тухай хууль болон Байгууллагын дотоод журмыг үндэслэн батлагдсан "Албан хаагчдын 2026 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хагас жилийн байдлаар үр дүнтэй зохион байгуулж, дараах ажлуудыг үе шаттай хэрэгжүүлэв. Үүнд: 1. Эрүүл мэнд, нийгмийн баталгааны хүрээнд: - Байгууллагын нийт албан хаагчдаас халдварт бус болон мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт элрүүлгийн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулснаас 8 албан хаагч, 2 албан хаагчийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод нарийн мэргэжлийн</p>	100

					<p>оношилгоо, шинжилгээнд хамрагдах 7 хоногийн хугацаатай эрүүл мэндийн аяллын эрхээр шагнаан аялуулсан.</p> <p>- Аймгийн Онцгой байдлын газар болон Нийгмийн даатгалын газартай хамтран албан хаагчдын амь нас, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, ирээдүйн нийгмийн баталгааг хангах чиглэлээр төрөлжсөн зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангасан.</p> <p>- Албан хаагчдын ар гэр, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэ хүүхэд өлгийдөн авсан болон ар гэрт нь хүндэтгэх шалтгаан тохиолдсон 7 албан хаагчид холбогдох журам, төсвийн хүрээнд мөнгөн дэмжлэг үзүүллээ.</p> <p>2.Хөрөнгө оруулалт, их засварын ажлын хүрээнд:</p> <p>- Аймгийн төсвийн 847.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Биеийн тамир, спортын газрын барилгын гадна фасадын угсралтын ажлыг “Перспектив шийдэл” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.</p> <p>- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баруунбүрэн сумын спорт цогцолборын их засварт 391.9 сая төгрөг (2026 оны санхүүжилт 200.0 сая төгрөг) төлөвлөгдөж, гүйцэтгэгчээр “Сайрын Харгана” ХХК, Ерөө сумын спорт цогцолборын их засварт 108.9 сая төгрөгөөр “Алсын хийморь” ХХК, Баянгол сумын спорт цогцолборын их засварт 162.8 сая төгрөгөөр “Уулс Дөл” ХХК тус тус шалгаран, 3 болон 4 дүгээр сард гэрээ байгуулан засварын ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Мандал спорт цогцолбор: 771.0 сая төгрөгийн их засварын зураг төслийг “Блю Мандал” ХХК-иар гүйцэтгүүлж, Онцгой байдлын улсын байцаагч болон “Сэлэнгэ барилга” ОНӨААТҮГ-аар магадлал хийлгэн, нэмэлт өөрчлөлт оруулахаар буцаагаад байна.</p> <p>3.Усан спорт сургалтын төв: Хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2026 оны 1-р улиралд 900 тонн усыг юүлж, сургалтын тавцангийн хөлийг гагнах, шүүлтүүр цэвэрлэх, ханыг эмүльсдэх зэрэг бэлтгэл ажлыг ханган, 3 дугаар сарын 21-ний өдрөөс усыг дахин дүүргэв.</p>
--	--	--	--	--	---

						<p>“Олимп Эргэл” ХХК-тай 16.5 сая төгрөгийн гэрээ байгуулан усан бассейны шал, ханыг зориулалтын 5-45°С-т тэсвэртэй будгаар 2 удаа будаж шинэчилсэн.</p> <p>- Мөн спорт заалны 563 м² акустик хавтангийн цэвэрлэгээг “Кристал жүрж бэлэг” ХХК-иар 7.3 сая төгрөгийн гэрээгээр гүйцэтгэсэн.</p> <p>4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2026 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Буур хээрийн 8 дугаар баг, “Сүхбаатар 90” цэцэрлэгт хүрээлэнд 20 ширхэг нарс мод тарьж, усалгаа, арчилгаа, хамгаалалтын хэвийн нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.</p>	
3.7	АНТХ-ийн 12.1, 14.6 Тэмдэглэлт өдрүүдэд байгууллагын ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-	Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулсан эсэх	1	2	<p>Ахмад настануудад хүндэтгэл үзүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах арга хэмжээг үе шаттай зохион байгуулсан. Үүнд:</p> <p>- Сар шинийн баяраар Ахмад настануудад баярын хүндэтгэл үзүүлж гарын бэлэг болон мөнгөн дэмжлэгийг хуулийн хугацаанд гардуулан өгөв.</p> <p>- Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлын хүрээнд байгууллагын ахмад 2 албан хаагчийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод нарийн мэргэжлийн оношилгоо, шинжилгээнд хамрагдах 7 хоногийн хугацаатай эрүүл мэндийн аяллын эрхээр шагнан аялуулж, бодит дэмжлэг үзүүлсэн.</p>	100
3.8	ЗГ-ын 278 дугаар тогтоол Төсөв, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн дагуу	-	-	<p>Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг чанд мөрдөн, байгууллагын төсөв, санхүү, эдийн засаг болон хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үе шаттайгаар зохион байгуулж, төсвийн сахилга батыг ханган ажилласан.</p> <p>Байгууллагын 2026 оны батлагдсан нийт төсөв болох 2,214,110,100 (Хоёр тэрбум хоёр зуун арван дөрвөн сая нэг зуун арван мянга нэг зуун) төгрөгөөс хагас жилийн байдлаар хуваарилагдсан үүнээс 1,052,879,200 (Нэг тэрбум тавин хоёр сая найман зуун далан есөн мянга хоёр зуун) төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвийн хуваарилалтыг дараах</p>	100

						<p>бүтцээр зохицуулан үр ашгийг тооцож ажиллав. Үүнд: Улсын төсвийн урсгал зардлын зохицуулалт: Эхний 6 сарын байдлаар батлагдсан 1,372,421,800 (Нэг тэрбум гурван зуун далан хоёр сая дөрвөн зуун хорин нэгэн мянга найман зуун) төгрөгийн санхүүжилтийн төсвөөс хагас жилийн байдлаар хуваарилагдсан 909,751,600 (Есөн зуун есөн сая долоон зуун тавин нэгэн мянга зургаан зуун) төгрөгийн санхүүжилтийг санхүүгийн сахилга батыг чанд сахиулж зөрчил, өр авлага үүсээгүй ажилласан.</p>	
3.9	Байгууллагын 2026 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн дагуу	-	-	<p>Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг чанд мөрдөн, байгууллагын төсөв, санхүү, эдийн засаг болон хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үе шаттайгаар зохион байгуулж, төсвийн сахилга батыг ханган ажилласан.</p> <p>Байгууллагын 2026 оны батлагдсан нийт төсөв болох 2,214,110,100 (Хоёр тэрбум хоёр зуун арван дөрвөн сая нэг зуун арван мянга нэг зуун) төгрөгөөс хагас жилийн байдлаар хуваарилагдсан 1,052,879,200 (Нэг тэрбум тавин хоёр сая найман зуун далан есөн мянга хоёр зуун) төгрөгийн санхүүжилт, нутгийн төсвийн хуваарилалтыг дараах бүтцээр зохицуулан үр ашгийг тооцож ажиллав. Үүнд: Улсын төсвийн урсгал зардлын зохицуулалт: Эхний 6 сарын байдлаар батлагдсан 1,372,421,800 (Нэг тэрбум гурван зуун далан хоёр сая дөрвөн зуун хорин нэгэн мянга найман зуун) төгрөгийн санхүүжилтийн төсвөөс хагас жилийн байдлаар хуваарилагдсан 909,751,600 (Есөн зуун есөн сая долоон зуун тавин нэгэн мянга зургаан зуун) төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан.</p>	100
3.10	Төсвийг эдийн засгийн ангилал хөтөлбөр зориулалтын дагуу хэрэгжилтийг хангах	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн дагуу	-	-	<p>Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалтын дагуу бүтэц, зохион байгуулалтын нэгжүүдэд хуваарилах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлсэн. Үүнд:</p>	100

						<p>-Хуваарилагдсан төсвийн санхүүжилтийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтын тогтмол зардал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зардал болон урсгал засвар, спорт цогцолборуудын үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийн ангилал бүрээр нь нарийвчлан зааглаж, зориулалтын дагуу хуваарилав.</p> <p>Байгууллагын харьяа нэгж, спорт цогцолборуудын үйл ажиллагааны онцлогт тохируулан төсвийн үр ашгийг тооцож, санхүүжилтийг цаг хугацаанд нь олгосон.</p> <p>Төсвийг зориулалт бусаар зарцуулахаас урьдчилан сэргийлж, батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн дотоод хяналтын дагуу ажилласан.</p>	
3.11	<p>АЭх-ийн 6.1.8, НАНБХАСЗУСТХ-ийн 23.3 Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулийн хэрэгжилтийг хангах</p>	-	Хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Байгууллагын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан хаагчдыг мэдээллээр хангах, хуулийн хугацаанд нь мэдүүлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулсан.</p> <p>Тус байгууллагад хуулиар хүлээсэн үүргийн дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах үүрэг бүхий нийт 4 албан хаагч Авлигатай тэмцэх газрын цахим системд /<i>meduuleg.iaac.mn</i>/ 2026 оны мэдүүлгээ хуулийн хугацаа болох 2 дугаар сарын 15-ны дотор зөрчилгүйгээр 100 хувь амжилттай гаргаж, баталгаажуулсан. Мэдүүлэгт дараах албан тушаалтнууд бүрэн хамрагдав.</p> <p>Үүнд: Биеийн тамир, спортын газрын дарга /ТЗ-4/ Биеийн тамирын хэлтсийн дарга /ТЗ-6/ Спортын хэлтсийн дарга /ТЗ-6/ Ерөнхий нягтлан бодогч /ТҮМ-7/ Хуулийн хугацаа хоцорсон, мэдүүлгээс татгалзсан болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүртгэгдээгүй.</p>	100
3.12	<p>Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах</p>	-	Хэрэгжилтийн хувь	80%	90%	<p>Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо 2026 оны төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Биеийн тамир, спортын улсын хорооноос 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан "Төрийн жинхэнэ</p>	100

						албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх, хориглох зүйл", Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар, Ёс зүйн академи хамтран зохион байгуулсан "Байгууллагын соёл ба ажилтнуудын ёс зүй, "Хувь хүний хөгжлийн менежмент" сэдэвт сургалтуудад "Байгууллагын албан хаагчдыг хамруулсан. БТСУХ-нд байгууллагын ёс зүйн дэд хорооны хууль, тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Ёс зүйн хорооны 09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтын дагуу 1 дүгээр улирал, хагас жилээр гарган хуулийн хугацаанд хүргүүлсэн. Албан хаагчдын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол эхний хагас жилд байхгүй.	
3.13	Мэдээллийн цахим санд (cpanel.sport.gov.mn) тэмцээн, наадам, сорилын мэдээг оруулах	-	Мэдээллийн тоо	1	2	Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан 6213 иргэний мэдээлэл, Монголын Үндэсний спортын өвлийн VIII наадамд Сэлэнгэ аймгаа төлөөлөн оролцох 18 тамирчны мэдээлэл, нийт 2 төрлийн мэдээллийг www.cpanel.sport.gov.mn сайтад оруулсан.	100
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт							
4.1	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн хэрэгжилтийг хангах	-	Архив, албан бичиг шийдвэрлэлтийн хувь	89%	92%	Архивын тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар болон холбогдох стандартуудын хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд чанд мөрдөн ажилласан. Хагас жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, дээд шатны байгууллагуудаас ирсэн болон явсан албан бичгийн бүртгэл, хяналт, шийдвэрлэлтийг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулав. Үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн голлох ажлууд: Албан бичиг шийдвэрлэлтийн хяналт: Хагас жилийн байдлаар дээд шатны байгууллага, орон нутгийн удирдлага болон иргэдээс ирсэн нийт албан бичиг, өргөдөл, гомдлыг удирдлагын зааврын дагуу хариуцах мэргэжилтнүүдэд хуваарилж, хуулийн хугацаанд нь хариуг албан ёсоор хүргүүлсэн. Хагас жилийн байдлаар хугацаа хоцорсон, шийдвэрлэлт дутуу үлдсэн албан бичиг	100

						<p>байхгүй бөгөөд шийдвэрлэлтийн явц, чанар 100 хувийн биелэлттэй байна.</p> <p>Цахим системийн ашиглалт: Албан хэрэг хөтлөлтийн ERP, Төрийн байгууллагын цахим шуудан, Gmail-г тогтмолжуулж, ирсэн, явсан бичгийн хяналтын картыг хөтлөн, үүрэг даалгаврын биелэлтийг сар бүр дотооддоо тооцон ажиллалаа.</p> <p>Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт ба Төрийн архив: Байгууллагын 2026 оны "Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт"-ыг батлуулан мөрдөж, дотоод нэгжүүдийн (Захиргаа, Биеийн тамирын алба, Спорт цогцолбор, Усан спортын сургалтын төв) оны эхний хагаст үүссэн анхан шатны баримт, тушаал, захирамж, тэмцээний удирдамж, протоколуудыг хувийн хэрэг үүсгэн стандартын дагуу цэгцэлж, архивын нэгж болгох бэлтгэл ажлыг хангасан.</p>	
			Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд баримт шилжүүлсэн байдал	89%	95%	<p>Архивын тухай хууль болон "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ын дагуу 2026 оны батлагдсан "Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт"-ыг үндэслэн хагас жилийн байдлаар хаагдсан албан хэрэг, баримт бичгийг архивын нэгж болгон цэгцлэх, шилжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулав.</p> <p>Авч хэрэгжүүлсэн ажлууд: Баримтын цэгцлэлт: Байгууллагын үндсэн захиргаа, Биеийн тамир, спортын алба болон харьяа Спорт цогцолбор, Усан спортын сургалтын төвийн хэмжээнд эхний хагас жилд хөтлөгдсөн албан тушаалтнуудын тушаал, захирамж, хурлын тэмдэглэл, санхүүгийн анхан шатны баримтууд, тэмцээний удирдамж, протокол, тайлангуудыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индексийн дагуу ангилан ялгаж, хувийн хэрэг үүсгэсэн.</p> <p>Архивт шилжүүлсэн байдал: Оны эхний хагаст хэрэгжиж дууссан бөгөөд хаагдсан нийт албан хэргийн баримтуудыг Архивын үндсэн стандартын дагуу үдэж хавтаслах, хуудаслах, дотоод товъёог үйлдэх, баталгааны хуудас бичих зэргээр</p>	100

						техникийн боловсруулалтыг чанартай хийж, байгууллагын архивт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	
4.2	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хос бичгээр хөтлөх	-	Хос бичгээр хөтөлсөн албан бичгийн хувь	50%	70%	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний бичигтэй хослуулан хэрэглэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд байгууллагын хэмжээнд гарч буй тушаал, шийдвэр болон гадагш явуулж буй албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлыг эрчимжүүлсэн. Хагас жилийн байдлаар байгууллагын даргын нийт 40 тушаал, гадагш илгээсэн 137 албан бичгийг кирилл болон үндэсний монгол бичгээр хослуулан, стандартын дагуу 100 хувь хос бичгээр үйлдэж баталгаажуулсан.	100
			Чадавхжуулсан албан хаагчийн тоо	1	4	Төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх, албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулж, хүний нөөцийг чадавхжуулж байна. Байгууллагын нийт 19 албан хаагчийг Сэлэнгэ аймгийн Насан туршийн боловсролын байгууллагатай хамтран Үндэсний Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамруулж сургалтын үр дүнд хагас жилийн байдлаар 3 албан хаагч хос бичигтэн болох түвшний шалгуурыг амжилттай хангасан.	100
4.3	ИТБАТГӨГШТХ-ийн 7.1 Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	-	Хуулийн хугацаанд хүргүүлсэн тайлан, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын хувь	75%	80%	Иргэд болон албан хаагчдад төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, нээлттэй, шуурхай хүргэх ажлыг байгууллагын хэмжээнд тогтмолжуулсан. Хагас жилийн байдлаар тус газар болон харьяа Спорт цогцолбор, Усан спортын сургалтын төвийн хэмжээнд иргэд болон албан хаагчдаас нийт 18 өргөдөл хүлээн авч, 100 хувь бүрэн шийдвэрлэсэн. Ирүүлсэн өргөдлийг агуулгаар нь ангилж, дараах байдлаар хуулийн хугацаанд зохион байгуулав. Үүнд: Ажилд орохыг хүссэн өргөдөл: Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу сул орон тоонд томилогдохоор ирүүлсэн өргөдлийг хүний нөөцийн сонгон шалгаруулалтын	100

					<p>үр дүнг үндэслэн хуулийн дагуу шийдвэрлэсэн.</p> <p>Ажлаас чөлөөлөгдөх (гарах) хүссэн өргөдөл: Албан хаагчдын өөрийн хүсэлт, тэтгэвэрт гарах болон бусад хүндэтгэх шалтгаанаар гаргасан өргөдлийг Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хянан үзэж, захиргааны тушаал шийдвэрийг хуулийн хугацаанд гаргасан.</p> <p>Чөлөө хүссэн өргөдөл: Ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн шалтгаан болон хувийн хүндэтгэх асуудлаар гаргасан албан хаагчдын чөлөө хүссэн өргөдөл тус бүрийг байгууллагын дотоод журам, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн, ажлын байрны тасралтгүй үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр шуурхай шийдвэрлэж чөлөө олгосон.</p>	
--	--	--	--	--	---	--

ХЯНАСАН: СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА У.БАТМӨНХ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН. ТОГТООЛ ШИЙДВЭР, ТАЙЛАН МЭДЭЭ, ХҮНИЙ
НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ОРХОНЧИМЭГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026.06.15.

Сүхбаатар

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Биеийн тамир, спортын газар төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2026 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.1-д заасны дагуу 2026 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 39 арга хэмжээнээс хагас жилийн байдлаар 39 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг зорилтот түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах бататгах ажлыг гүйцэтгэв.

**Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн
хяналт-шинжилгээний үр дүн**

"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.5-д зааны дагуу Биеийн тамир, спортын газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 4 зорилт хүрээнд 39 арга хэмжээнээс жилийн хэрэгжилт тайлагнавал зохих 39 арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийхэд 33 арга хэмжээ "Бүрэн хангалттай" буюу 85 түүнээс дээш хувь, 1 арга хэмжээ 70-85 хүртэл хувь, дүгнэх боломжгүй 5 арга хэмжээг хасаж тооцсон ба арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **99,7** хувьтай буюу "Бүрэн хангалттай" гэж дүгнэгдлээ.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Хувь
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	
39	100 хүртэл	85 хүртэл	70 хүртэл	Дундаж хувь 99,7
	33	1	-	

Шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд нийт арга хэмжээний 94,1 хувь нь бүрэн хангалттай буюу 100-85 хувьтай байна.

График 1



2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээний задаргаа

№	Дэс дугаар	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь
Зорилт-1 Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 3.5, ЗГҮАХ “2024-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.4, МУХТЖҮЧ-ийн 1.2.2			
1	1.1.1	МУЕ-ийн 53 дугаар зарлиг Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг зохион байгуулах, сорилын программд үр дүнг шивж оруулах	100
	1.1.2	“МУЕ-ийн 53 дугаар зарлиг, АЗДҮАХ 2.4.1.4 “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-д сорилын үйл ажиллагааг зохион байгуулах	100
2	1.1.3	МУ-ын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлиг Бүх нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	76
	1.1.4	БТСтХ-ийн 30 дугаар зүйл, ХБХЭтХ-ийн 33, 42 дугаар зүйл Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран тэмцээн, биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах	98,5
	1.1.5	АЗДҮАХ 2.4.1.1 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд аян зохион байгуулж, “Би сэлж сурлаа” анхан шатны тэмцээн	100

		зохион байгуулах	
	1.1.6	АЗДҮАХ 2.4.1.5 "Сэлэнгийн Мөнгөн Өвөл-2026" арга хэмжээг иргэдийн дунд зохион байгуулах	100
	1.1.7	АНТХ-ийн 11.1.2 Ахмадын нас биеийн онцлогт тохирсон тэмцээн, биеийн тамирын арга хэмжээг спорт холбоодтой хамтран зохион байгуулах	100
	1.1.8	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.3 Улс, аймаг, бүсийн болон нэрэмжит тэмцээнийг спорт холбоодтой хамтран зохион байгуулах	100
	1.1.9	Улс, аймаг, бүс, нэрэмжит тэмцээнд Өсвөр үе, насанд хүрэгчдийг оролцуулах	100
	1.1.10	Үндэсний спортын тэмцээнийг спорт холбоотой хамтран зохион байгуулах	100
	1.1.11	БТСтХ-ийн 13.1.4 Өвлийн багийн спортын тамирчдын ур чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлэх	100
	1.1.12	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.3 Өсвөрийн шигшээ спортын төрлийг нэмэгдүүлэх	100
	1.1.13	Спортын хэрэглэл материалын хүртээмжийг сайжруулах	-
	1.1.14	БТСтХ-ийн 13.1.10 Шинээр хөгжиж буй спортын төрлийг хөгжүүлж, иргэдэд сурталчлах	100
	1.1.15	Хамтарсан бэлтгэл, сургалтыг Аймгийн хэмжээнд зохион байгуулах	100
Зорилт 1.2 "Спортлог Сэлэнгэ"-чүүд хөтөлбөрийн хүрээнд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах			
	1.2.1	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 "Сэлэнгэ Марафон" гүйлтийн арга хэмжээг зохион байгуулах	100
	1.2.2	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 Монголын уламжлалт тоглоом, наадгайн арга хэмжээг зохион байгуулах	-
1	1.2.3	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын тэмцээн, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах,	-
	1.2.4	"Сэлэнгийн Оюутан Залуус-2026" Спортын II наадмыг зохион байгуулах	-
	1.2.5	БТСтХ-ийн 13.1.4, АЗДҮАХ 2.4.1.1 "Сэлэнгэ Лиг-2026" спортын наадмыг зохион байгуулах	100
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт			
	2.1	НМИТБТХ-ийн 8 дугаар зүйл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, газар болон цогцолборын ил тод байдлын хэрэгжилтийг хангах	94
2	2.2	ЗГХЭГД-ын 100 дугаар тушаал Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хагас, бүтэн жилээр тайлагнах.	100
	2.3	ҮСХД-ын А/646 тоот тушаал Байгууллагын жилийн статистик мэдээг нэгтгэж хүргүүлэх.	100
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт			
3	3.1	ЗГ-ын 43 дугаар тогтоол Байгууллагын 2026 оны Хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-	100

		шинжилгээ, үнэлгээ хийх	
	3.2	ЗГ-ын 311 дугаар тогтоол Байгууллагын Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах	100
	3.3	БТСТХ-ийн 14.1.6 Биеийн тамир, спортын салбарын улсын IV зөвлөгөөнд оролцох	-
	3.4	ТАЗ-ийн 2025 оны 521 дугаар тогтоол "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу харьяа Спорт цогцолборуудын эрхлэгч, арга зүйч нарын болон төрийн албан хаагчдын хувийн хэргийг хөтөлж, баяжилт хийх	100
	3.5	Байгууллагын албан хаагчдын 2026 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	100
	3.6	Байгууллагын албан хаагчдын 2026 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	100
	3.7	АНТХ-ийн 12.1, 14.6 Тэмдэглэлт өдрүүдэд байгууллагын ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	100
	3.8	ЗГ-ын 278 дугаар тогтоол Төсөв, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах	100
	3.9	Байгууллагын 2026 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах	100
	3.10	Төсвийг эдийн засгийн ангилал хөтөлбөр зориулалтын дагуу хэрэгжилтийг хангах	100
	3.11	АЭх-ийн 6.1.8, НАНБХАСЗУСТХ-ийн 23.3 Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулийн хэрэгжилтийг хангах	100
	3.12	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	100
	3.13	Мэдээллийн цахим санд (срanel.sport.gov.mn) тэмцээн, наадам, сорилын мэдээг оруулах	100
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт			
4	4.1	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн хэрэгжилтийг хангах,	100
	4.2	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хос бичгээр хөтлөх	100
	4.3	ИТБАТГӨГШТХ-ийн 7.1 Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	100
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн			99,7

Дөрөв: Дүгнэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлтэд үнэлгээ өгөх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх, гарсан алдаа дутагдлыг арилгах, дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дундаж " Бүрэн хангалттай" буюу 85-100 хүртэл хувьтай үнэлэгдсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн

төлөвлөгөөний 4 зорилт 39 бүхий арга хэмжээнээс 33 арга хэмжээ 100 хувь хэрэгжсэн байна.


Мөн хэрэгжилт хийгдээгүй 1.1.13, 1.2.2, 1.2.3, 1.2.4, 3.3 арга хэмжээ хугацаа болоогүй учир зохион байгуулагдаагүй байна.

“Бүрэн хангалттай” буюу 85-аас дээш үнэлэгдсэн 33 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Тус биеийн тамир, спортын газар нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.6,3,8 Төсөв, санхүү, эдийн засаг хөрөнгө оруулалтыг төлөвлөх хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах ажил Биеийн тамир спортын газарт нийт 1.310.770.113.төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн, зэрэг ололттой талууд байна.

Барилга байгууламжийн урсгал болон их засвар спортын талбай хэрэглэл материалын үйл ажиллагаа төсөв санхүүтэй холбоотойгоор төлөвлөгдсөн үйл ажиллагаа 2026 онд хийгдэхээр улсын болон орон нутгийн төсөвт тусгагдсан байна.

ХЯНАСАН: БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА  У.БАТМӨНХ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Г.ЭНХТҮВШИН